



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газар болон харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 28,500,000.00 (хорин найман сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 5,042,458.30 (таван сая дөчин хоёр мянга дөрвөн зуун тавин найман төгрөг гучин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, хавсралтад заасан байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн
380 дугаар тогтоолын хавсралт

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэх хуулийн этгээдийн нэр
1	Гаалийн ерөнхий газар	Зөөврийн компьютер /HP/	2024	5	ш	3,230,000.00	16,150,000.00	3,028,124.97	13,121,875.03	Төрийн албаны зөвлөл
2		Зөөврийн компьютер /Dell/	2024	1	ш	3,580,000.00	3,580,000.00	447,500.01	3,132,499.99	
3		Ухаалаг самбар /IQ tech/	2024	1	ш	5,300,000.00	5,300,000.00	1,104,166.65	4,195,833.35	
4	Увс аймаг дахь Гаалийн газар	Суурин компьютер /Dell/	2024	1	ш	3,470,000.00	3,470,000.00	462,666.67	3,007,333.33	Эрүүгийн цагдаагийн алба
Нийт дүн										
									23,457,541.70	
									(хорин гурван сая дөрвөн зуун тавин долоон мянга таван зуун дөчин нэг төгрөг далан мөнгө)	